



НӨМҮН САНГИЙН ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
Ц.ОДОНЧИМЭГ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgov@audit.gov.mn

2016.11.04 № 01/32

Төлбөр барагдуулах тухай

Аймгийн Аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн төв номын сангийн 2016 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрлын аудитаар **797,587.00** /Долоон зуун ерин долоон мянган таван зуун наян долоон/ төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Гэрээр ном олгох болон карт нээсний орлогын тооцоо бодоогүйгээс үндсэн үйл ажиллагааны орлого 741,650.00 төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.6-д /төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаанаас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана./ мөн Аймгийн засаг даргын 2009 оны 97 дугаар захирамжаар батлагдсан “Үнэт цаас, тасалбарын маягт хэвлүүлэх, бүртгэх, зарцуулах журам”-ын 3.6-д /Төлбөрт үйлчилгээ, хураамж хураах тухай бүр хариуцсан ажилтанд үнэт цаас, тасалбарын маягтыг актаар хүлээлгэн огч орсон орлого, зарцуулалтын тайлланг тогтолц болон төлбөрт үйлчилгээ үзүүлсний дараах ажлын 1 өдрийн дотор гаргуулан тооцоо бодож, орлогыг байгууллагын дансанд тушаалгаж байна/ гэж заасныг;

- Ажилтанд чөлөөтэй байсан 2 өдрийн хугацаанд 55,937.00 төгрөгийн цалинг илүү тооцож олгосон.

Энэ нь Санхүү, эдийн застийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2006 оны 06 сарын 25 ны өдрийн 171/111 тоот тушаалын хавсралтын 4.2-т /... Ажлын цагийн тооцоог үндэслэн цалин холсний тооцоог хийх .../ гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад шлэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах судитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад шлэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг

арилгуулах зорилгоор толборийн акт, албан шаардлага өгөх¹, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д /Улсын болон орон нутгийн төсөв, Засгийн газрын тусгай сан, хөтөлбөр, биеэ даасан эрхийн актаар зохицуулагддаг сан хөтөлбөр батлагдсан толөвлөгөөнд тусгагдсан орлогыг дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй/ мөн тус журмын 3.1.3-д /Бусдад өгөх толбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон/ гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. **797,587.00** /Долоон зуун ерин долоон мянга таван зуун наян долоон/ төгрөгийг холбогдох албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Дундговь аймгийн Төрийн сан банк дахь орон нутгийн төсвийн 080000955 дугаар дансанд 2016 оны 12 дугаар сарын 25-ны дотор төвлөрүүлэх,

Актын биелэлтийг 2016 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Номын сангийн төсвийн шууд захирагчийн үүрэг гүйцэтгэгч Ц.Одончимэг, Нягтлан бодогч А.Эрдэнэмөнх нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН¹:

Аудитор:  Т.Оюун-Эрдэнэ/

ЗӨВШӨӨРСОН:

Захирал:  Ц.Одончимэг/
Нягтлан бодогч:  А.Эрдэнэмөнх/

ТОВ НОМЫН САН

9033025 2 4816129907

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны давуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.